

# Компанийн засаглалын жилийн үйл ажиллагааны тайлан

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН  
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр**

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт		
<p>"Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.</p> <p>Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекст дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.</p>		
<p align="center"><b>НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</p>		
	Хэрэгжилт	Тайлбар
1	<p>1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ГУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ГУЗ-ийн дарга, ГУЗ-ийн дэргэдэх хорооны бүтэц, гишүүдийн эрх, үүрэг, Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.</p>
2	<p>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ГУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолоор ГУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан.</p>
3	<p>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд ГУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ердийн болон харуут бус гишүүдийн ажлын туршлага болон бусад мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнадаг.</p>

4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	<b>Биелүүлсэн:</b> ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон түүний дэргэдэх хороод нь бүтэц, бүрэлдэхүүн, хорооны эрх, үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан журамтай бөгөөд уг журмаараа гишүүдийн ажлын туршлага, мэргэшлийг тодорхойлно.	
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	<b>Биелүүлсэн:</b> ТУЗ-д шинээр сонгогдсон, түр томилогдсон гишүүдэд ТУЗ-ийн үйл ажиллагааг танилцуулж, холбогдох дүрэм, журмын сургалт хийдэг. Мөн Компанийн засаглалын сургалтад суугаагүй бол уг сургалтад суулгадаг.	
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	<b>Биелүүлсэн:</b> ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлж өгсөн бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах үүрэгтэй.	
<b>ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>  Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ			
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	<b>Хэсэгчлэн хэрэгжүүлсэн</b>	Компанийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй ба 3 хараат бус, 6 ердийн гишүүнтэй. Бид ойрын хугацаанд хараат бус гишүүний тоог нэмэгдүүлж 4 хараат бус гишүүнтэй болохоор ажиллаж байна.

8	<p>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Журамд заасны дагуу компанийн Дотоод аудитын хорооны даргаар Хараат бус гишүүн ажилладаг бөгөөд хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох эрхгүй ба шаардлагатай тохиолдолд хүсэлтээр оролцдог.</p>	
9	<p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан. Журамд хорооны дарга нь ердийн эсвэл хараат бус гишүүн байх эсэхийг заагаагүй боловч гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус байхыг заасан. Мөн хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох эрхгүй ба шаардлагатай тохиолдолд хүсэлтээр оролцдог.</p>	
10	<p>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталсан. Журамд хорооны дарга нь ердийн эсвэл хараат бус гишүүн байх эсэхийг заагаагүй боловч гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус байхыг заасан. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн дарга ажилладаггүй.</p>	

11	<p>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, хороодын чиг үүрэг зэргийг зохицуулдаг бол ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ч хорооны чиг, үүрэг, бүтэц, хурлын зохион байгуулалт, шийдвэр гаргалт, гишүүдийн ажлын туршлага, ажиллах журмыг тодорхойлсон.</p>	
<p><b>ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</p>			
12	<p>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/15 тоот тогтоолоор “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам”-ыг баталсан. Уг журмаар компанийн үнэн зөв мэдээллийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад хүргэдэг.</p>	
13	<p>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн засаглалын кодекстэй холбоотой засаглалын журам, зааврыг компанийн албан ёсны цахим хуудаст байршуулж олон нийтэд хүргэдэг.</p>	

14	<p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу тайлагнадаг, санхүүгийн бус тайланд эдгээр мэдээллийг танилцуулдаг.</p>	
<p><b>ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</p>			
15	<p>4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Мөн ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/14 тогтоолоор Хөндлөнгийн аудит томилох журмыг баталсан ба уг журмаар хараат бус аудитыг сонгох, томилох харилцааг зохицуулсан бөгөөд Дотоод аудитын хороо хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг.</p>	
16	<p>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Хөндлөнгийн аудитыг аудитын тайлан, дүгнэлтээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг шаардаж ажилладаг бөгөөд сүүлийн 3 жил буюу 2020-2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудит нь тайлан, дүгнэлтээ танилцуулсан.</p>	

17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	<b>Биелүүлсэн:</b> Компанийн албан ёсны цахим хуудас болон жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн чиг үүрэг, хариуцлага, тухайн жилд ТУЗ-өөс гаргасан шийдвэр зэргийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудад тухай бүр мэдээлдэг.	
<b>ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b> Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина			
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	<b>Биелүүлсэн:</b> ТУЗ-ийн дэргэдэх Санхүү,Зээл, Эрсдэлийн хороо нь эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Компанийн бүтцэд Эрсдэлийн удирдлагын газар багтдаг бөгөөд ТУЗ-өөс уг газрын эрхэлсэн захирлыг томилж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавьж ажилладаг.	
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	<b>Хэсэгчлэн хэрэгжүүлсэн</b>	ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, Зээл, Эрсдэлийн хорооны журмыг баталсан. Санхүү, Зээл, Эрсдэлийн хорооны журмаар хорооны бүтэц, гишүүдийн тоо, үүрэг, хариуцлага болон хуралдаан зохион байгуулах, шийдвэр гаргах зэрэг хорооны бүх үйл ажиллагааг зохицуулсан.

20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	<b>Биелүүлсэн:</b> Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд манай компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн боломж нь байгаль орчин болон харилцагчид хэрхэн нөлөөлж буй талаарх мэдээллийг хүргэдэг.	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	<b>Биелүүлсэн:</b> ТУЗ-өөс компанийн Комплайнс хариуцсан ажилтанг томилон ажиллуулдаг бөгөөд уг ажилтан нь ТУЗ-д ажлаа тайлагнадаг.	
<p style="text-align: center;"><b>ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b></p> <p>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна</p>			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	<b>Хэсэгчлэн хэрэгжүүлсэн</b>	ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ баталдаг. Цаашид буюу 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас эхлэн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. Компанийн хувьд ТУЗ-ийн цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн батлуулах бүрэн боломжтой юм.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	<b>Биелүүлсэн:</b> Компани нь Гүйцэтгэлийн үнэлгээний журмыг үйл ажиллагаандаа мөрддөг бөгөөд уг журмаар ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж цалин, урамшууллын хэмжээг тогтоодог.	



24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	<b>Хэсэгчлэн хэрэгжүүлсэн</b>	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд өнгөрсөн санхүүгийн жилд гаргасан компанийн санхүү болон үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг тусгадаг. Жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгах бүрэн боломжтой бөгөөд 2022 оны жилийн үйл ажиллагааны тайланд уг шалгуур үзүүлэлтийг тусгах болно.
----	---	-------------------------------	--

**ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Ард Кредит ББСБ ХК нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалттай бөгөөд 13,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй юм. Бид хөрөнгө оруулагч үндэстэнг бий болгох уриатай ажиллаж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудын эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажилладаг. Манай компанийн ТУЗ болон ажилтнууд бүгд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэн, хамтран ажиллах соёлыг аль хэдийн бий болгосон. Компанийн Хөдөлмөрийн дотоод журмаар ажилтантай хамтран ажиллах харилцааг, Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангахыг “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам”-аар зохицуулж байна.</p>	
----	--	---	--

26	<p>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, ажлын талаарх мэдээллийг танилцуулдаг. 2021 онд нийгмийн хариуцлагын чиглэлд голчлон анхаарч ажилласан бөгөөд дараах томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Ид Шидийн Орон” төвд 26 хүний суудалтай Nissan civilian автобус бэлэглэсэн,</li> <li>2. 100 сувилагчид 100 сая төгрөгийн тусламж үзүүлсэн,</li> <li>3. “NO ONE LEFT BEHIND. TOGETHER” төслийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, JCI Централ ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн,</li> <li>4. Тэрбум мод хөдөлгөөнд оролцсон.</li> </ol>	
27	<p>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн албан ёсны <a href="http://www.ardcredit.com">www.ardcredit.com</a> цахим хуудсыг тогтмол ажиллуулж, компанийн засаглал, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хамтран ажиллаж буй байгууллагууд болон компанийн үйл ажиллагаанд гарсан онцлог үйл явдлуудын талаарх мэдээллийг харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудад байнга хүргэж мэдээллээр ханган ажиллаж байна.</p>	

28	<p>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 21/А/82 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн Дотоод журамд ажилтны гомдол, саналыг хүлээн авах, шийдвэрлэх харилцааг нарийн зохицуулсан ба ажилтны нийгмийн асуудал болон мэргэжил, дээшлүүлэх сургалт, хөгжил, карьер төлөвлөлтийн асуудлыг мөн тусгайлан зохицуулсан байна.</p>	
<p><b>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</b></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</p>			
29	<p>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ТУЗ-ийн 2014 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 15А тогтоолоор ТУЗ-ийн Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Уг ёс зүйн дүрмийн шинэчилсэн найруулгыг бэлтгэж, зөвхөн ТУЗ-ийн бус нийт ажилтан, гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж буй этгээд болон ТУЗ-ийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон Компанийн Ёс зүйн дүрмийг боловсруулсан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах ТУЗ-ийн ээлжит бус хурлаар хэлэлцэн батлуулахаар ажиллаж байна.</p>	

30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	<b>Биелүүлсэн:</b> Компанийн үйл ажиллагаанд илэрсэн аливаа хууль бус үйлдэл, зөрчлийн талаарх мэдээллийг Комплайнс хариуцсан ажилтан холбогдох зөрчлийн хамрах хүрээний хувьд хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд, санхүүгийн тайлагнал, залилан, ашиглантай холбоотой асуудлыг Дотоод аудитын хороонд, зээл, эрсдэлтэй холбоотой асуудлыг Санхүү, Зээл, Эрсдэлийн хороонд тус тус мэдэгдэж ажиллаж байна.	
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	<b>Биелүүлсэн:</b> Компанийн Ёс зүйн дүрмийн шинэчилсэн найруулгаар авлига, албан тушаалтай холбоотой хориглосон заалт, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх заалтуудыг тусгасан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах ТУЗ-ийн ээлжит бус хурлаар Ёс зүйн дүрмийг батлах болно.	
<b>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b> Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	<b>Биелүүлсэн:</b> Компанийн албан ёсны <a href="http://www.ardcredit.com">www.ardcredit.com</a> цахим хуудас, "Ard Credit" Facebook хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, зээлдэгч, холбогдох төрийн байгууллага зэрэг бүх оролцогч талуудад зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.	

33	<p>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчтай тогтмол харилцах цахим сувгийг хөгжүүлсэн бөгөөд info@ardcredit.com имэйл хаяг, www.ardcredit.com цахим хуудас, “Ard Credit” Facebook хаягуудаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.</p> <p>Компанийн хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах ТУЗ-ийн ээлжит бус хурлаар хэлэлцэн батлуулахаар ажиллаж байна.</p>	
34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр хуульд заасан хугацаанд зохион байгуулж байна. Хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд ТУЗ-өөр батлуулан хувьцаа эзэмшигчдэд жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлж, тэдний санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бүрэн мэдээллээр хангаж, хууль ёсны эрх ашгийг нь хүндэтгэн ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар асуулт асууж хариулт авах, санал, гомдол, хүсэлтээ илэрхийлэх бүрэн боломжоор ханган ажиллаж байна.</p>	

35	<p>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, сонирхлын зөрчилтэй их хэмжээний хэлцэл хийх, компанийн өрийг хувьцаагаар солих зэрэг хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн бүтэцтэй холбоотой шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг бөгөөд хэрэв сонирхлын зөрчилтэй асуудал хэлэлцвэл санал хураалтад зөвхөн сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчид оролцдог.</p>	
36	<p>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</p>	<p><b>Биелүүлсэн:</b></p> <p>ГУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/14 тоот тогтоолоор Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа даган мөрдөж байна.</p>	
<p><b>Санамж:</b></p> <p>Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.</p> <p>Тухайлбал, "МХБ" ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.</p> <p>Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.</p>			